



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/775

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 18 дугаар зүйлийн 18.1.5, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн скаутын бүлгэмийн шинэ гишүүдийг чадавхжуулах зорилгоор монголын скаутын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бүлгийн удирдагч, салааны дарга бэлтгэх анхан шатны сургалтад оролцуулсугай.

2.Сургалтад оролцоход шаардагдах 3,800,000 (гурван сая найман зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Уул уурхайн компаниудтай байгуулсан Нийгмийн хариуцлагын гэрээний санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

